



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/64

Булган сум

Хүүхдийн хоолны зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 207 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн хүүхдийн хоолны зөвлөлийн дүрмийг 1 дүгээр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоол, “Үдийн хоол”-ны чанар, аюулгүй байдалд хяналт тавих, хүүхдийн хоол хүнсний хангамж, чанарын асуудлаар иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийг судлан холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэхийг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.


3.“Хүүхдийн хоолны зөвлөл”-ийг өөрийн суманд байгуулж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцон үр дүнг танилцуулахыг зөвлөлийн дарга (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР





БУЛГАН АЙМГИЙН ХҮҮХДИЙН ХООЛНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг: Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү дүрэм нь Булган аймгийн хүүхдийн хоолны зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ -ийн өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын, “Үдийн хоол”, дотуур байрны хоол, хүнсний хангамж, чанарын асуудлаар эцэг эх, нийлүүлэгч байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдол хүсэлтийг судлан холбогдох байгууллагад санал тавих, асуудлыг шуурхай шийдвэрлүүлэх чиг үүрэг бүхий байгууллага мөн.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа “төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” Боловсролын ерөнхий хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийг байгуулах, ажиллуулах:

2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 8 хүртэл байх бөгөөд 60-аас доошгүй хувь нь эцэг, эхийн, үлдсэн хувийг холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй байгуулна.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүний эцэг эхийн төлөөллийг сургууль, цэцэрлэгүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн сонгоно.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагаа:

3.1. Зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, хүүхдийн хоол, хүнсний хангамж, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа баталгаатай газар дээр танилцах, хяналт тавих, зөвлөн туслах

3.1.2. Эцэг, эх, асран хамгаалагч, багш, суралцагч, иргэд, нийлүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн гомдол, хүсэлтийг судлан дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагуудад санал тавих.

3.1.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

3.2. Хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэр гаргаж, тэмдэглэл хөтөлнө. Зөвлөлийн хурлын шийдвэрт дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.3. Зөвлөл нь аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн болон Боловсролын газрын баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэмдгийг хэрэглэж болно. Зөвлөл нь үйл ажиллагааны жил улирлын төлөвлөгөө гаргаж төлөвлөгөө гаргаж ажиллана.

3.4. Зөвлөл нь улирал тутам хуралдах бөгөөд зайлшгүй тохиолдолд ээлжит бус хурлыг зөвлөлийн дарга болон нийт гишүүдийн 50-аас доошгүй хувийн саналаар хуралдуулна.

3.5. Зөвлөлийн хурлын товыг хурал болохоос 3-ас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хүргүүлнэ.

3.6. Зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар мэргэжлийн болон бусад байгууллагын ажилтан, тухайн сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, эмч, сургалтын

менежер, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, суралцагч, бүтээгдэхүүн нийлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагын төлөөллийг хуралд оролцуулан тэдний санал, хүсэлт, тайлбарыг сонсож болно.

3.7.Зөвлөлийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд

3.7.1.Зөвлөлийн гишүүдийн ажил, үүргийн хуваарийг батлан мөрдүүлэх

3.7.2.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох, хурлын товыг тогтоох, зарлах, бэлтгэлийг хангуулах, хурлыг удирдан явуулах, шийдвэрийг батламжлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

3.7.3.Зөвлөлөөс томилсон ажлын хэсгийн хийж ажлын чиглэлийг тогтоох, удирдамжийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих

3.7.4.Зөвлөлийн хурлын шийдвэр, үйл ажиллагааны үр дүнгийн тухай аймгийн Засаг даргад танилцуулж, Боловсролын газрын, сургууль, цэцэрлэгийн удирдлагад чиглэл өгөх

3.7.5.Зөвлөлийн хийсэн ажлын тайланг улирал бүр Боловсролын яам болон аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

3.8.Зөвлөлийн гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.8.1.Зөвлөлийн хурлын шийдвэрийг сурталчилах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3.8.2.Зөвлөлийн дарга болон хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, дүнг мэдээлэх

3.8.3.Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, хариуцсан асуудлын хүрээнд танилцах, туслах зөвлөх

3.8.4.Зөвлөлийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох албан тушаалтанд шаардлага тавих, түүний биелэлтийн байдалтай танилцах, тайлбар гаргуулах

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 02 -ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

БУЛГАН АЙМГИЙН ХҮҮХДИЙН ХООЛНЫ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Боловсролын газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын
хяналтын улсын ахлах байцаагч

Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй
байдал хариуцсан мэргэжилтэн

Боловсролын хяналтын улсын байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн

бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Боловсролын газрын Сургалтын орчин, хүүхдийн хоол
үйлдвэрлэл, үйлчилгээний ахлах арга зүйч